



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 4/67

Улаанбаатар хот

Г Баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр томилох тухай


Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, тус газрын дүрмийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын тулгар төр байгуулагдсаны 2224, Их Монгол улс байгуулагдсаны 809 жилийн ой, Үндэсний их баяр наадмын үеэр нийслэлийн нутаг дэвсгэр дэх аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагууд, гадаадын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, байгууллагын өрөө тасалгаа, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор үндэсний их баяр наадмын өдрүүдэд буюу 2015 оны 7 дугаар сарын 11-нээс 13-ны өдөр ажиллах ажилтнуудын хуваарийг хавсралтаар баталсугай.


2. Баярын өдрүүдэд тус газрын эрхлэх ажлын хүрээнд хамаарах асуудлаар шуурхай шийдвэрлэх нөхцөл байдал үүссэн үед газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ажиллах хариуцлагатай жижүүрт мэдэгдэж, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг нийт ажилтнуудад, төв цэнгэлдэх хүрээлэн, Хүй-7 худагт жуулчдын аюулгүй байдал, мэдээллээр шуурхай хангах, зохицуулж, хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн Д.Ганболдод, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Э.Мөнхзул нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Э.БАТТУЛГА



Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2015 оны 07 сарын 10 өдрийн
167 тоот тушаалын хавсралт



**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ҮЕЭР АЖИЛЛАХ
АЖИЛТНУУДЫН ХУВААРЬ**

№	Хийж хэрэгжүүлэх ажлууд	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Ажиллах цаг
1	Хүй долоон худагт жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, явуулын мэдээллийн цэг ажиллуулах	7 дугаар сарын 11,12,13-ны өдрүүдэд	Д.Энхбаяр	09:00-20:00
2	Төв цэнгэлдэх хүрээлэнд жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, явуулын мэдээллийн цэг ажиллуулах	7 дугаар сарын 11,12-ны өдрүүдэд	Н.Алтанзаяа	09:00-20:00
3	Баяр наадмын нээлтийн үеэр 3 дугаар хаалган дээр ажиллах	7 дугаар сарын 10,11-ний өдөр	Д.Ганболд Б.Эрбахыт Н.Халиун	08:00-12:00
	Баяр наадмын нээлтийн үеэр 4 дүгээр хаалган дээр ажиллах		М.Баасандорж Б.Оюунзул С.Туул	
	Баяр наадмын нээлтийн үеэр 15 дугаар хаалган дээр ажиллах		Ш.Ундармаа Б.Амарзаяа Б.Болортуяа	
	Баяр наадмын нээлтийн үеэр 16 дугаар хаалган дээр ажиллах		Б.Жаргалан М.Болортуяа Д.Монголхүү	
4	Чингисийн талбайд /Дээлтэй монгол наадам/	7 дугаар сарын 10-ны өдөр	Бүх ажилтнууд	16:00-21:00
5	Мэдээлэл сурталчилгааны төвд хариуцлагатай жижүүрээр ажиллах	7 дугаар сарын 11-ний өдөр	Б.Халиун	09:00-20:00
		7 дугаар сарын 12-ны өдөр	Б.Ербахыт	09:00-20:00
		7 дугаар сарын 13-ны өдөр	М.Баасандорж	09:00-20:00